



БҮЛЭГ 1. Орон нутгийн өмчийн хөрөнгө бэлтгэх, бүртгэх, данснаас хасаж, акталж үстгах үйл ажиллагааг хууль, журмын хүрээнд оновчтой зохион байгуулахгүй байна.

1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлдэггүй, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд ОНӨГ-ын оролцоог хангадаггүйгээс хөрөнгийн хуваарилалт оновчтой бус байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 141 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дансанд 254.5 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь аудитаар баталгаажсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 129.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Энэ нь улсын төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгийг ОНӨГ бүртгэж ТӨБЗГ-г тайлагнадаг бол ТЕЗ-ийн санхүүгийн тайланд тусгадаггүйтэй холбоотой байна.

ОНӨГ-ын ашигладаг тооллогын системээр гаргадаг үндсэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийн тайлан нь жил бүрийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас зөрүүтэй ба 2020 оны үлдэгдэл 17.5 тэрбум, 2021 оны үлдэгдэл 18.3 тэрбум, 2022 оны үлдэгдэл 112.2 тэрбум төгрөгийн зөрүүтэй байна. Үүнээс харахад ОНӨГ, СТСХ нь тооцоо нийлж тулган баталгаажуулдаггүй, үйл ажиллагааны уялдаа холбоо муу байна. Иймд дээрх онуудын хөрөнгийн бүртгэлийн зөрүүг арилгаж, тооцоо нийлж баталгаажуулах, цаашид байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулан, хамтран ажиллах шаардлагатай байна.

ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдэд нэн шаардлагатай хөрөнгийн хэрэгцээ, эрэмбэ дарааллын талаар гаргаж нэгтгэсэн тооцоо судалгаа, тоон мэдээлэл байхгүй, ашиглаж байгаа программ нь хөрөнгийн мэдээллийг дансны төрөл, байршил, үйл ажиллагааны салбар зэрэг үзүүлэлтээр боловсруулдаггүй байна. Энэ нь сум, байгууллагын хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хөрөнгийн хуваарилахтай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар бүртгэлтэй үндсэн хөрөнгийг аймаг, сумдаар авч үзвэл:


Хүснэгт-1 /сая.төг/

Аймаг, сумын нэр	2022 он	2023 он	Өөрчлөлт
АЗД-ын харьяа байгууллага	51,792.3	54,887.1	6.0%
Адаацаг	5,144.2	8,158.7	58.6%
Баянжаргалан	5,740.5	6,022.3	4.9%
Говь-Угтаал	4,518.2	5,151.5	14.0%
Гурвансайхан	11,882.8	13,298.7	11.9%
Дэлгэрхангай	7,895.9	8,604.5	8.9%
Дэлгэрцогт	5,354.6	6,180.0	15.4%
Дэрэн	7,023.6	7,432.3	5.8%
Луус	3,693.0	4,379.2	18.6%
Өлзийт	10,332.3	11,275.3	9.1%
Өндөршил	6,285.7	7,096.3	12.9%
Сайнцагаан	23,140.3	26,091.7	12.7%
Сайхан-Овоо	7,787.5	12,819.6	64.6%
Хулд	5,706.5	7,296.5	27.9%
Цагаандэлгэр	2,697.4	3,058.0	13.4%
Эрдэнэдалай	11,541.8	15,083.2	30.7%

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Хүснэгтээс харахад Сайхан-Овоо сум 64.6 хувь, Адаацаг сум 58.6 хувь, Эрдэнэдалай сум 30.7 хувиар өссөн бол Баянжаргалан, Дэрэн сумын хөрөнгө 4.9-5.8 хувиар өсжээ.


Хөрөнгийн хэмжээг үйл ажиллагааны салбараар авч үзвэл:



Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Графикаас харахад боловсролын болон төрийн захиргааны байгууллагад хамгийн их хөрөнгө бүртгэлтэй байна. Спорт, соёл урлагийн салбарын хөрөнгө хамгийн их буюу 20.5 хувиар, эрүүл мэндийн салбарын хөрөнгө 19.1 хувиар, боловсролын салбар 17.4 хувиар, төр захиргааны салбарын хөрөнгө 13.0 хувиар өссөн байна.

Сумдын барилгаас бусад үндсэн хөрөнгийг 2023 оны байдлаар хүн амын тоотой харьцуулж үзвэл 1 хүнд Гурвансайхан сум 3.1 сая, Өлзийт сум 2.8 сая, Сайхан-Овоо сум 2.3 сая, Өндөршил сум 2.3 сая төгрөг буюу хамгийн өндөр, Сайнцагаан сум 0.6сая, Эрдэнэдалай сум 0.9 сая төгрөгийн хөрөнгө ноогдож байгаа нь хамгийн бага байна.



Хөрөнгийн өөрчлөлтийг харахад 1 хүнд ноогдох хөрөнгө ихтэй Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо сумдын хөрөнгө илүү нэмэгдсэн бол Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын хөрөнгө харьцангуй бага боловч өсөлт мөн бага байна.

Сумдын хөрөнгийг 2023 оны байдлаар төрийн албан хаагчдын тоонд харьцуулан үзвэл 1 төрийн албан хаагчид ноогдох хөрөнгө Өлзийт суманд 68.7 сая, Гурвансайхан суманд 61.0 сая,

Сайхан-Овоо суманд 49.4 сая, Өндөршил суманд 35.8 сая төгрөг буюу хамгийн их байгаа бол Сайнцагаан суманд хамгийн бага буюу 14.6 сая төгрөг ноогдож байна. Харин бусад сумдад 24.1-30.0 сая төгрөг байна.

График-3




Графикаас харахад 1 төрийн албан хаагчид ноогдох хөрөнгө ихтэй Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Өндөршил сумдын хөрөнгө илүү нэмэгдсэн байна. Энэ нь хөрөнгийн хуваарилалт оновчтой бус, тооцоо судалгаа хийдэггүйтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 17 ерөнхий боловсролын сургуулийн ашиглаж байгаа 19 барилгын нийт суурилагдсан хүчин чадал 6,640 хүүхэд хүлээн авах боломжтойгоос 6,765 хүүхэд хүлээн авч хүчин чадал ашиглалт 101.9 хувь буюу ачаалал хэтрэлт 1.9 хувь байна.

“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт 2020 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байрыг шинээр барих хэрэгцээ шаардлагаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч, шинээр баригдаж байгаа тул дээрх тооцоололд ороогүй болно. Цэгц билиг сургуулийн барилга нь анх дотуур байрны зориулалттай баригдсан ба хичээлийн байрны зориулалтаар ашигласнаас хойш хүчин чадлыг шинэчлэн тогтоогоогүй тул хүчин чадал ашиглалтын тооцоолол хийх боломжгүй байна.


График-4



Дээрх графикаас харахад Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургууль 88.3 хувь, Эрдэнэдалай сумын сургууль 21.9 хувь, Дэлгэрхангай сумын сургууль 20.6 хувь, Мандал сургууль 12.4 хувь, Цагаандэлгэр сумын сургууль 3.0 хувийн ачаалал хэтрэлттэй байна. Харин Говь-Угтаал сумын сургуулийн хүчин чадлын ашиглалт 49.7 хувь буюу ашиглагдаагүй хүчин чадал хамгийн өндөр, Дэрэн, Хулд, Өлзийт, Луус, Өндөршил, Баянжаргалан сумдын сургуулийн ашиглагдаагүй хүчин чадал 30.0–49.7 хувь байна.

Төрийн өмчийн 22 цэцэрлэгийн ашиглаж байгаа 26 хичээлийн барилга нийт суурилагдсан хүчин чадал 2,645 хүүхэд хүлээн авах боломжтойгоос 3,128 хүүхэд хүлээн авч аймгийн хэмжээнд цэцэрлэгийн барилгын нийт хүчин чадал ашиглалт 118.3%-тай буюу ачаалал хэтрэлт 18.3 хувь байна.

График-5



Сайнцагаан сумын цэцэрлэгүүд ачаалал хамгийн их буюу 46.0-91.2 хувийн ачаалал хэтрэлттэй, Дэлгэрхангай 24.0 хувь, Хулд 15.6 хувийн ачаалал хэтрэлттэй байгаа бол Өндөршил,

Өлзийт, Луус, Баянжаргалан сумдын цэцэрлэгийн ашиглагдаагүй хүчин чадал 20.0-48.6 хувьтай байна.

Сургуулиудын хичээлийн байрны зориулалтаар ашиглаж байгаа 20 барилгаас 9 нь 40-өөс дээш жил ашиглаж байгаа насжилт өндөр барилга байна.

График-6



Хамгийн олон жил ашиглаж байгаа Эрдэнэдалай сумын сургуулийн хичээлийн 2 дугаар байрыг 72 жил ашиглаж, ашиглалтын хугацаа дууссан бол Сайхан-Овоо, Дэрэн, Дэлгэрхангай, Гурвансайхан, Өндөршил, Сайнцагаан сумын Мандал сургуулийн барилга насжилт бага шинэ барилгууд байна.

Цэцэрлэгийн хувьд 26 барилга ашиглаж байгаагаас Говь-Угтаал сумын цэцэрлэгийн барилга 60 жил ашигласан бол 40-өөс дээш жилийн насжилттай 8 цэцэрлэг, 10-аас доош жилийн ашиглаж байгаа 9 цэцэрлэг байна.

График-7



ОНӨГ нь барилгын ашиглалт, насжилт, хүчин чадлын ашиглалтын талаар тооцоо судалгаа хийдэггүйгээс хөрөнгө оруулалт оновчтой бус хуваарилагдах эрсдэлтэй байна. Иймд цаашид барилгын насжилт, хүчин чадлын ашиглалт, хэрэгцээ шаардлагыг харгалзан хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилахад анхаарах нь зүйтэй байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2023 онд Адаацаг, Говь-Угтаал, Өлзийт сумын сургуулийн барилгад, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Өлзийт, Эрдэнэдалай, Сайнцагаан сумын 4, 6 дугаар цэцэрлэгүүдэд их засвар хийгдсэн байна. Засвар хийгдсэн 10 барилгын 8 нь 30-аас дээш жил ашигласан бол Дэлгэрхангай, Дэрэн сумын цэцэрлэг засвар хийх үед тус бүр 7 жил ашигласан барилга байсан байна. Энэ хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл зарим талаар оновчтой бус, чанаргүй хийгдэж байгааг харуулж байна.

Дундговь аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит 73 хуулийн этгээдэд 10,005.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 387 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 97 мотоцикль, 13 чиргүүл, 277 автомашин байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд бүртгэлтэй автомашины тоог үйл ажиллагааны салбараар авч үзвэл хамгийн олон буюу 117 автомашин төр захиргааны байгууллагад бүртгэлтэй байгаа бол эрүүл мэндийн салбарт 54, боловсролын салбарт 23 автомашин бүртгэлтэй байна.

Хүснэгт-2

Салбар, зориулалт	Автобус, микро автобус	Ачааны	Суудлын	Тоноглосон, тусгай зориулалтын	Трактор, механизм	Нийт
Боловсрол	20	1	1		1	23
Бусад	5	2	3		1	11
ОНӨААТҮГ	3	22	2	6	8	41
Спорт, соёл урлаг	6					6
Төр захиргаа	13	40	40	9	15	117
Хууль хяналт	5		20			25
Эрүүл мэнд	17	4	17	16		54
Дүн	69	69	83	31	25	277

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Бүртгэлтэй автомашиныг зориулалтаар нь ангилбал суудлын автомашин 83, автобус 69, ачааны машин 69 байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй суудлын зориулалттай автомашиныг хөдөлгүүрийн багтаамжаар авч үзвэл хүчин чадал өндөр, туулах чадвар сайтай 44 автомашин төр захиргааны байгууллагад ашиглагдаж байгаа бол эрүүл мэндийн салбарт 7, боловсролын салбарт 1 байна.

Хүснэгт-3

Салбар, хөдөлгүүрийн багтаамж	1001-2000 см ³	2001-3000 см ³	3001см ³ -ээс дээш	Нийт
Боловсрол	5	17	1	23
Бусад	1	8	2	11
ОНӨААТҮГ	7	10	24	41
Спорт, соёл урлаг		4	2	6
Төр захиргаа	22	51	44	117
Хууль хяналт	19	5	1	25
Эрүүл мэнд	12	35	7	54
Дүн	66	130	81	277

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Салбарын онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзан автомашины хүчин чадал, туулах чадвар зэргийг харгалзан үзэж, тооцоо судалгаанд үндэслэн хөрөнгийг хуваарилах шаардлагатай байна.

ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дутагдалтай тээврийн хэрэгслийн судалгаа гаргуулан авдаггүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлдоггүй, дүн шинжилгээ хийдэггүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өмчийн харилцаатай холбоотой холбогдох журмуудыг судалдаггүй, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж буй талаар тавих хяналт хангалтгүй нь шаардлагагүй хөрөнгийг бэлтгэх, хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг судлахгүй оновчтой бус хуваарилах шалтгаан болж байна. ОНӨГ “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх,

данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу хөрөнгө бэлтгэх саналаа хүргүүлж, төсөв, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлтийн үе шатны оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Шинээр нэмэгдсэн хөрөнгө:

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2020-2023 онд нийт 109.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр дансанд бүртгэсэн ба жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 2 жилд шинээр нэмэгдсэн хөрөнгийг үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

Хүснэгт-4 /сая.төг/

Он	Боловсрол	Төр захиргаа	ОНОААТҮГ	Эрүүд мэнд	Спорт, соёл урлаг	Хууль хяналт	Бусад	Нийт нэмэгдсэн хөрөнгө
2022	7,952.8	6,522.1	7,759.6	5,064.6	2,984.9	56.9	459.9	30,800.9
2023	11,762.8	8,435.2	2,813.6	6,239.9	3,857.8	126.9	396.8	33,633.1

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Боловсрол болон төрийн захиргааны байгууллагууд хамгийн их хөрөнгийг шинээр бэлтгэсэн байна. Шинээр бүртгэсэн хөрөнгийг эх үүсвэрээр авч үзвэл 2023 онд улсын төсвөөс 15.9 тэрбум, орон нутгийн төсвөөс 9.9 тэрбум төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

Хүснэгт-5 /сая.төг/

Он	Нэмэгдсэн хөрөнгө	Эх үүсвэр						
		Улсын төсвөөс	Орон нутгийн төсвөөс	Хандив, тусламжаар	Өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогоос	Балансаас балансд шилжүүлсэн	Дахин үнэлгээ	Бусад
2022	30,800.9	8,934.1	5,907.9	986.0	333.1	759.2	-	13,880.6
2023	33,633.1	15,950.2	9,970.6	1,751.8	204.6	633.1	1,539.9	3,582.9

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Орон нутгийн өмчит хуулийн этгээд “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2¹ дах заалтад заасны дагуу өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг бэлтгэн саналаа ОНӨГ-т ирүүлж, эд хөрөнгө бэлтгэх зөвшөөрлийг авдаггүй байна.

Орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг шинээр нэмэгдсэн хугацаагаар авч үзвэл 2020-2023 онд хамгийн их буюу 127 бүртгэсэн нь 2016-2019 онд нэмэгдсэнээс 50 автомашинаар илүү байна.

Хүснэгт-6

Салбар, бүртгэсэн он	2011-ээс өмнө	2012-2015	2016-2019	2020-2023	Нийт
Боловсрол	2	5	5	11	23
Бусад	3	3	4	1	11

¹ “... өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараагийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг бэлтгэн саналаа жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор ОНӨГ-т хүргүүлнэ.”

ОНӨААТҮГ	3	9	14	15	41
Спорт, соёл урлаг	1	2	2	1	6
Төр захиргаа	10	26	26	55	117
Хууль хяналт		3	8	14	25
Эрүүл мэнд	2	4	18	30	54
Дүн	21	52	77	127	277

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Үйл ажиллагааны салбараар харвал 2020-2023 онд төр захиргааны байгууллагууд 55 автомашин шинээр нэмэгдсэн бол спорт, соёл урлагийн салбар 1 автомашин нэмэгдсэн байна. Орон нутгийн өмчид 2020 онд 37, 2021 онд 39, 2022 онд 16, 2023 онд 35 автомашин шинээр бүртгэсэн боловч тээврийн хэрэгсэл худалдан авах саналаа орон нутгийн өмчийн газарт хүргүүлж зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4²-д заасан ОНӨГ-аас зөвшөөрөл авах заалтыг огт хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт-7

Он, салбар	Боловсрол	Эрүүл мэнд	Төр захиргаа	Спорт, соёл урлаг	Хууль хяналт	ОНӨААТҮГ	Бусад	Нийт
2020	5	14	10	1	5	2		37
2021	6	2	16		7	8		39
2022		6	8			2		16
2023		8	21		2	3	1	35
Дүн	11	30	55	1	14	15	1	127

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Орон нутгийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авахдаа ОНӨГ-т саналаа хүргүүлж зөвшөөрөл авах зохицуулалтыг мэддэггүй, ОНӨГ-аас арга зүйгээр хангадаггүй, хяналт тавьдаггүй явсаар ирсэн байна. Энэ нь хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна. Цаашид орон нутгийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл бэлтгэхдээ зөвшөөрөл авах, ОНӨГ тээврийн хэрэгслийн нөхцөл байдалд дүгнэлт хийж төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд саналаа хүргүүлэх замаар шийдвэрлэж хэвших шаардлагатай байна.

Зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдийг түүвэрлэн ажигласан байдал:

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа хэвийн үр ашигтай явуулахад шаардлагатай хөрөнгө, техник хэрэгслийн хэрэгцээ, шаардлагаа тодорхойлодоггүй мөн тооцоо судалгаа хийж эрэмбэлдэггүй байна. Тус байгууллага нь 2021 онд 296.7 сая төгрөг, 2022 онд 1,207.9 сая төгрөг, 2023 онд 677.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу дансанд бүртгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,787.9 сая төгрөгийн үнэ бүхий Залуус хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугамыг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэхээр аймгийн ИТХ-ын 2022 оны 49 дүгээр тогтоол гарсан боловч 2023 онд 313.2 сая төгрөгийн үнэлгээтэй гадна цэвэр, бохир усны шугамыг бүртгээд, 1,474.7 сая төгрөгийн үнэлгээтэй гадна дулааны шугам, узелийг дансанд бүртгээгүй байна. Энэ нь “Дундговь-Ус” ОНӨААТҮГ

² “Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүр орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авна. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо, төрөл, өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийн ашиглалт зэргийг харгалзана”

аймгийн ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлээгүй, ОНӨГ үндсэн хөрөнгөнд бүртгэсэн эсэхэд хяналт тавьж, зөрчлийг арилгаагүй байна. Зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Шинээр баригдсан цэвэрлэх байгууламжийн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 4 тээврийн хэрэгсэл /Саарал ус зөөврийн машин, ковш, экскаватор, жижиг экскаватор/-ийг цэвэрлэх байгууламжийг хүлээж аваагүй гэсэн шалтгаанаар үндсэн хөрөнгөд бүртгээгүй, ашиглаж байна. Эдгээр хөрөнгийг хүлээн авах үед эвдрэл, гэмтэл үүсвэл хэн хариуцах нь тодорхойгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна. Иймд “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дугаар зүйлийн 4.8³ дах заалтад заасны дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэх шаардлагатай байна.

“Тэвшийн говь” ХХК-ны халаалтын үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/39 дүгээр захирамжийн дагуу халаалтын үйл ажиллагааг 2023.02.01-ний өдрөөс “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т түр хугацаанд хариуцуулж, аймгийн ИТХ-ын 2023 оны 37 дугаар тогтоолоор 1, 2 дугаар зуухны барилга, холбогдох байгууламжийг доорх газрын хамт шилжүүлж үндсэн хөрөнгөнд бүртгэх зөвшөөрлийг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т олгожээ. Дулаан үйлдвэрлэхэд ашиглаж байгаа хөрөнгө нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр битүүмжтэй байгаа тул хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх, ашиглах, гарсан гэмтэлд засвар үйлчилгээ хийх эрх үүсээгүй байна.

“Мандалын гэгээ” хот тохижуулах газар ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа үр ашигтай явуулахад шаардлагатай хөрөнгө, техник хэрэгслийн хэрэгцээ шаардлагаа тодорхойлдоггүй мөн тооцоо судалгаа хийж эрэмбэлдэггүй байна. Тус байгууллага нь 2020 онд 227.2 сая төгрөг, 2021 онд 3,294.9 сая төгрөг, 2022 онд 4,345.9 сая төгрөг, 2023 онд 2,066.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэсэн байна.

Хөрөнгийг дансанд бүртгэхдээ 47 тооны 3,275.4 сая төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэсэн нь “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1⁴-т заасан хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан бүртгээгүй байна. Ингэснээр хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих боломжгүй, ашиглах боломжтой хөрөнгө бөөн дүнгээр актлагдах, хөрөнгө шамшигдах эрсдэлтэй байна.

1.2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг актлах, данснаас хасах шалгуур үзүүлэлт байхгүй, дуудлагын худалдаагаар худалдах үндсэн хөрөнгийн үнэ хаялцах доод хязгаарыг ТӨБЗГ-аас баталсан журамд нийцүүлэн батлаагүй байна.

Дундговь аймгийн ТЕЗ-ийн 2020-2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх данснаас хасагдсан хөрөнгийн дүн ОНӨГ-ын дүнгээс зөрүүтэй байна. /Зөрүүг хүснэгтээр харуулбал:/

№	Байгууллага	2020	2021	2022	Хүснэгт-8
					2023
1	ТЕЗ	8,343.0	6,130.2	91,082.6	17,766.8
2	ОНӨГ	5,332.1	6,408.9	13,574.4	4,643.6
	Зөрүү	3,011.0	(278.8)	77,508.2	13,123.1

Зөрүүг тодруулахад дараах шалтгаануудтай байна.

³ “... хөрөнгийг тухай орон нутгийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг ОНӨГ-т нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ.”

⁴ “... хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан...”

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангаарх тоон мэдээлэл ОНӨГ-ын гаргаж ирүүлсэн тоон мэдээллээс 278.8-13,123.1 сая төгрөгөөр зөрүүтэй харагдаж байна. Энэ нь улсын төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгийг ОНӨГ бүртгэж ТӨБЗГ-т тайлагнадаг бол ТЕЗ-ийн санхүүгийн тайланд тусгадаггүй.

- “Төрийн өмчийн тооллогын систем” нь хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэж, үлдэгдлийг тайлагнах бөгөөд данснаас хассан үндсэн хөрөнгийг дансны ангиллаар биш нийт дүнгээр гардаг;
- ОНӨГ нь АИТХТ-ийн тогтоолоор данснаас хасаж, акталсан хөрөнгийг СТСХ-тэй тооцоо нийлж баталгаажуулдаггүй байна. Энэ нь ажил хариуцсан ажилтны идэвх санаачилга муутай, ажилдаа хариуцлагагүй ханддаг байдал, байгууллагуудын ажлын уялдаа холбоо муутай холбоотой байна.

Иймд “Төрийн өмчийн тооллогын систем”-ийг сайжруулах, ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гарах бүрд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой тоон мэдээллийг СТСХ-тэй тооцоо нийлж баталгаажуулж байх шаардлагатай байна.

Аудитын явцад 2022-2023 оны тоон мэдээллийн зөрүүг арилгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 18,218.0 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Хүснэгт-9 /сая төгрөгөөр/

Он	Худалдсан	Балансаас балансад шилжүүлсэн	Акталсан	Данс хооронд шилжсэн	Бусад	Дахин үнэлгээ	Нийт дүн
2022	54.4	3,057.9	2,192.3	2.6	8,267.2		13,574.4
2023	87.0	632.7	1,660.2	55.8	357.7	1,850.2	4,643.6
Нийт	141.4	3,690.6	3,852.5	58.4	8,624.9	1,850.2	18,218.0

Данснаас хассан хөрөнгийн 20 хувь буюу 3,690.6 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр балансаас балансад шилжүүлж, дансны ангилал хооронд зөрүүтэй бүртгэсэн 58.4 сая төгрөг буюу 0.3 хувийг данс хооронд шилжүүлж, 3,852.5 сая төгрөг буюу 21.1 хувийг данснаас хасаж, акталсан байна. Данснаас хассан хөрөнгийг салбар тус бүрээр нь авч үзвэл: *График-8*



Боловсролын салбар 38 хувь буюу 6,997.7 сая төгрөг, төрийн захиргааны байгууллага 30 хувь буюу 5,499.1 сая төгрөг байгаа нь хамгийн их, хууль хяналтын байгууллага 0.2 хувь буюу 36.4 сая төгрөгийг данснаас хассан нь хамгийн бага байна. Дундговь аймгийн ТЕЗ-ийн хэмжээнд 2020-2023 онд 58 удаагийн дуудлагын худалдаа зохион байгуулж 45 нэр төрлийн хөрөнгийг борлуулж, 272.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ. Харин 2022-2023

онд давхардсан тоогоор 48 нэр төрлийн 357.5 сая төгрөгийн хөрөнгийг 2-4 удаа зарласан боловч оролцогч ирээгүй байна. Мөн 2021 онд 2 нэр төрлийн 4.9 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг 0.3 сая төгрөгийн доод үнээр дуудлага худалдаа зарлаж -4.5 сая төгрөгөөр борлуулагдсан боловч худалдан авагч нь хуульд заасны дагуу 14 хоногийн дотор төлбөрөө төлөөгүй тул дуудлага худалдаа амжилтгүй болсон байна. Дээрх онуудад амжилтгүй болсон дуудлагын худалдаанд орсон

хөрөнгүүдээс Адаацаг сумын ЗДТГ-т ашиглагдаж байсан Nissan murano автомашинаас бусад хөрөнгүүд бүрэн худалдагдсан байна.

Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох батлагдсан аргачлал одоогоор байхгүй байна. Сангийн яамны 2016 оны 131 дүгээр тушаалаар “Төрийн өмчийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” журмын 6.3-д дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнийн шалгуур үзүүлэлтийн баталсан байна. Харин АИТХТ-ийн 2017 оны 51 дүгээр тогтоол “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах” журамд энэ талаар заалт тусгаагүй байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журамд ямар шалгуур үзүүлэлтээр хөрөнгийн үнэлгээг хэрхэн тогтоож дуудлага худалдаагаар худалдан борлуулах тухай заасан зүйл заалт байхгүй, зөвхөн бүрдүүлэх бичиг баримтыг тусгасан байна.

Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоохдоо сум, байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөл анхны үнээс элэгдлийн зардлыг хассан дүн болон хөрөнгийн чанарыг харгалзан саналаа ОНӨГ-т ирүүлж байна. Ирүүлсэн саналын дагуу Орон нутгийн өмчийн газар АИТХТ-ын хуралд оруулж худалдах үнийг батлуулсан байна.

Хөрөнгийн үнэлгээний зардлыг гаргах боломжгүй шалтгаанаар ИТХ-ын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 2.4.5⁵-т заасны дагуу Говийн ирээдүй цогцолбор сургуулийн “А”, “Б” дотуур байрнаас бусад үл хөдлөх хөрөнгөнд үнэлгээ хийлгээгүй байна. Үнэлгээ хийх зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 3⁶ хэсэгт тодорхой заасан байна. Энэ тогтоолын дагуу дуудлагын худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний болон бусад зардлыг шийдвэрлэж, эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгэж байх шаардлагатай байна.

Худалдах үл хөдлөх хөрөнгөнд эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгэсэн тайлан байхгүй байгаа нь тухайн хөрөнгийг бодитой бус үнэлэх, бусад давуу тал олгох, ашиг сонирхол үүсэх үр дагавартай байна. Цаашид “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журамд данснаас хасах, дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн үнэ тогтоох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгах, дуудлага худалдаагаар худалдах доод үнийг тогтоох аргачлал, дуудлага худалдаа зохион байгуулах /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38-45 дугаар зүйл баримтална/ талаарх заалтыг оруулж шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Дуудлагын худалдааны зарын мэдээллийг “Зууны мэдээ”, “Дундговийн амьдрал” сонинуудаар 2022-2023 онуудад 34 хөрөнгийн мэдээллийг 47 удаа иргэдэд хүргэж мэдээлсэн бөгөөд 2020-2021 оны хэвлэлд өгсөн зарим мэдээлэл архивын баримт материал үдэгдээгүй гэсэн шалтгаанаар байхгүй байна.

Дуудлагын худалдааг нийтэд зарлахдаа худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлийг зарим зар мэдээлэлд мэдээлээгүй байна. Энэ нь дуудлага худалдаанд оролцогчдод худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлийг урьдчилан танилцах боломж олгохгүй, тэднийг дуудлагын худалдаанаас татгалзах, амжилтгүй болох үр дагавартай байна.

⁵ /худалдах үл хөдлөх хөрөнгөнд эрх бүхий байгууллагаар хийлгэсэн үнэлгээний тайлан/

⁶ Төсөвт байгууллагын дансанд бүртгэлтэй, төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдаанаас олсон орлогоос тухайн дуудлагын худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардал (хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бол үнэлгээний төлбөр, дуудлагын худалдааны зар мэдээ байршуулахад төлсөн төлбөр)-ыг хассан дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсугай.

ОНӨГ нь Худалдан авах ажиллагааны газартай нэг цахим хуудастай байсан тул дуудлагын худалдааны мэдээллийг бүрэн оруулдаггүй байжээ. Тус байгууллага нь 2024 оноос тусдаа үйл ажиллагаа явуулж эхэлснээр өөрийн цахим хуудастай болж 7 нэр төрлийн хөрөнгийн дуудлагын худалдааны зар мэдээг оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 2⁷-т заасны дагуу дуудлагын худалдааг дахин зохион байгуулахдаа 14 хоногоос доошгүй хугацаанд зарласан байна. Дахин дуудлагын худалдаагаар давхардсан тоогоор 48 нэр төрлийн хөрөнгөөс 47 хөрөнгө худалдагдсан байна.

Харин АИТХТ-ийн 2017 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.1⁸-т заасны дагуу 14 хоногоос 5 нэр төрлийн хөрөнгийн зарыг 11-273 хоногийн хугацаа хэтрүүлэн зарласан байна. Говийн ирээдүй цогцолбор сургуулийн дотуур “А” байр 104 хоногоор, “Б” байр 170 хоногоор хугацаа хэтэрч зарлагдсан байна. Тухайлбал: Адаацаг сумын ЗДТГ-т ашиглагдаж байсан Nissan muino 20-66 ДУЭ маркийн автомашиныг АИТХТ-ийн шийдвэр гарсан өдрөөс 21 хоногийн дараа буюу 7 хоногоор хугацаа хэтрүүлж зарлагдсан байна. Тус тээврийн хэрэгслийг 3 удаа дуудлагын худалдаагаар худалдах зар хүргэсэн боловч амжилтгүй болж, одоогоор тоногдсон байдалтай Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын хашаанд хадгалалт, хамгаалалтгүй байна. Иймд дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийг АИТХТ-ын 2017 оны 51 дүгээр тогтоолд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан маягтын дагуу нийтэд зарлан мэдээлж, хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүй байх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2020-2023 онд 0.1-10.0 сая төгрөгийн худалдах үнэтэй 41 нэр төрлийн, 10.0 сая төгрөгөөс дээш худалдах үнэтэй 4 нэр төрлийн хөрөнгийг АИТХТ-ийн 2017 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1⁹, 5.2¹⁰-т заасны дагуу дуудлагын худалдааны үнэ хаялцах хязгаарыг баримтлан үнэ хаялцуулсан байна. Дээрх тогтоолоор баталсан үнэ хаялцах доод үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын 1 дэх хэсэг, 2023 оны 616 дугаар тогтоолоор баталсан нэмэлт өөрчлөлттэй нийцүүлж батлаагүй байна. Дуудлагын худалдаагаар 2020-2023 онд худалдсан хөрөнгүүд нийлбэр дүнгээр худалдах доод үнээс 43-85 хувиар өсөж борлуулагдсан байна.

Хүснэгтээр харуулбал: Хүснэгт-10

Он	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ	Худалдсан үнэ	Худалдах доод үнээс өссөн хувь
2020	156,142.0	34,624.1	27,010.0	50,060.0	85.0
2021	140,290.2	4,081.4	31,600.0	54,300.0	72.0
2022	82,500.0	56,748.3	26,000.0	26,000.0	-
2023	279,418.0	18,497.4	99,700.0	142,250.0	43.0
Нийт дүн	658,350.2	113,951.2	184,310.0	272,610.0	47.9

⁷ Дуудлагын худалдааг дахин явуулах шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргах бөгөөд дахин дуудлагын худалдаа явуулах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө энэ тухай мэдээлнэ...

⁸ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор дуудлага худалдааны зар мэдээг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан маягтын дагуу нийтэд зарлан мэдээлнэ.

⁹ дуудлагын худалдаагаар худалдаа эд хөрөнгийн худалдах доод үнэ 10,000,000/арван сая/ хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 50,000 /тавин мянга/, дээд хязгаар 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөг байна.

¹⁰ дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдах доод үнэ 10,000,001 /арван сая нэг/ төгрөгөөс дээш бол хаялцах доод хязгаар 100,000 /нэг зуун мянга/ төгрөг, дээд хязгаар дэнчингийн хэмжээтэй тэнцүү байна.

Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгүүд худалдах доод үнээс 1.1-40 дахин өсөж борлуулагдсан байна. Энэ нь эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгэж, худалдах доод үнийг тогтоолгохгүй өмч хамгаалах байнгын зөвлөл болон ОНӨГ-аас АИХТХ-д оруулж буй үнийн санал бодитой бус байна гэж дүгнэхээр байна. Говийн ирээдүй цогцолбор сургуулийн А, Б дотуур байрны үнэлгээг “Итгэлт-Эстимэйт” ХХК-аар хийлгэж үнэ тогтоосон нь борлуулагдсан үнэтэй буюу ойролцоо буюу 1.1 хувиар өсөж борлуулагдсан байна. Цаашид дуудлагын худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийг үнэлгээний эрх бүхий байгууллагаар зайлшгүй хийлгэх тухай журамд тусгаж, хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

“Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах” журамд үл хөдлөх хөрөнгийг эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийх талаар заалт байхгүй байна. Тус тогтоолын хэрэгжилтийг жил бүрээр тооцож гаргаагүй бөгөөд хэрэгжилтийг тайлагнах тухай дээрх тогтоолд тусгаагүй байна. Энэ нь ажил хариуцсан байгууллага, ажилтнуудын хариуцлагыг сулруулах үр дагаврыг бий болгож байна. Дуудлагын худалдааг цахимаар зохион байгуулсан удаа байхгүй байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын дагуу энэ онд журамд өөрчлөлт оруулахаар бэлтгэн аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

АИТХТ-ийн тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдан борлуулах орон нутгийн өмчит бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг эрх бүхий байгууллагаар үнэлгээ тогтоолгон худалдаагүй байна.

Аудитаар Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургууль, 2 дугаар Цэцэрлэгийн барилгын буулгалтаас гарсан материалыг худалдан борлуулах АИТХТ-ийн тогтоолоор баталсан үнийг материал борлуулсан үнэтэй тулган баталгаажууллаа.

Хүснэгт-11

+	Байгууллагын нэр	АИТХТ-ийн тогтоолоор	Борлуулсан үнэ	Үлдэгдэл	Зөрүү
1	Хүмүүнлэг сургууль	11.9	11.2	0.7	-
2	Говийн ирээдүйн цогцолбор сургууль	23.9	16.1	3.7	4.1
3	2 дугаар цэцэрлэг	6.2	7.0	-	(0.8)
	Нийт дүн	42.0	34.3	4.4	3.3

Дээрх гурван байгууллагын барилгын буулгалтаас гарсан материалын үнэлгээг нийт 42 сая төгрөгөөр тогтоож, 34.3 сая төгрөгийн материалыг борлуулж, 4.4 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй, 4.1 сая төгрөгийн материал дутагдаж байна.

Хяналтын тооллогоор Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгаас гарсан халаалтын 408 ширхэг 3.5 сая төгрөгийн радиатор, бусад материал 0.6 сая төгрөг нийт 4.1 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. Тус зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг барилгын материалын үнэлгээг Сайнцагаан сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 6.2 сая төгрөгөөр худалдахаар шийдвэрлэж, 7.2 сая төгрөгөөр борлуулсан байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2022-2023 онд нийт данснаас хассан 18,218.0 сая төгрөгийн хөрөнгө байгаагаас 3,852.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Үүнээс үлдэх өртөгтэй хөрөнгө 897.3 сая төгрөг буюу 23 хувийг эзэлж байна.

Хүснэгт-12

№	Он	Балансын дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	2022	740.3	322.1	418.3
2	2023	157.0	47.1	110.2
	Нийт дүн	897.3	369.1	528.5